



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ГЭМТ ХЭРЭГ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА 2018



Улаанбаатар хот
2019 он

**ХЯНАСАН:**

Д.Мөнхзул

ЧД-ын Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

М.Батхишиг

ЧД-ын Статистикийн хэлтийн ахлах
мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ III БАЙР, 401 тоот
Утас: 70113013
976-11-310767
70130767
70110767

Цахим хуудас: www.ubstat.mn
www.chingeltei.gov.mn

И-мэйл: chingeltei@nso.mn



ГЭМТ ХЭРЭГ

Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт 2018 онд бүртгэгдсэн гэмт хэрэг 2776 болж, өмнөх оноос 58 (2.1%) хэргээр өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 34.1 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.6 пунктээр буурсан байна.


Гэмт хэргийн гаралт Монгол Улсын хэмжээнд 36220 болж өмнөх оноос 3961 (12.3%) хэргээр, Нийслэлийн хэмжээнд 3705 (16.9%) хэргээр тус тус өссөн байна.

Хүснэгт 1. Монгол Улс, нийслэл, дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэрэг, оноор

Захиргаа	2014	2015	2016	2017	2018	Өөрчлөлт	2018/2017
Улсын дүн	27 318	27 757	27 167	32 259	36 220	3 961	12.3%
Нийслэлийн дүн	17 144	17 939	17 909	21 947	25 652	3 705	16.9%
Чингэлтэй	2 392	2 254	2 337	2 719	2 776	57	2.1%
Багануур	236	311	293	254	253	-1	-0.4%
Багахангай	23	21	23	31	24	-7	-22.6%
Баянгол	2 775	2 951	3 137	3 204	4 501	1 297	40.5%
Баянзүрх	4 263	4 272	4 218	5 939	7 522	1 583	26.7%
Налайх	339	423	489	393	420	27	6.9%
Сонгинохайрхан	3 039	3 232	2 962	3 691	3 692	1	0.0%
Сүхбаатар	2 593	3 085	2 811	3 816	4 132	316	8.3%
Хан-Уул	1 484	1 390	1 639	1 900	2 332	432	22.7%

Нийслэлийн хэмжээнд гэмт хэргийн гаралт 16.9 хувиар өсөхөд Баянгол дүүрэг 40.5 хувиар, Баянзүрх дүүрэг 26.7 хувиар, Хан-Уул дүүрэг 22.7 хувиар, Сүхбаатар дүүрэг 8.3 хувиар, Налайх дүүрэг 6.9 хувиар, Чингэлтэй дүүрэг 2.1 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Харин гэмт хэргийн гаралт Багахангай дүүрэгт 22.6 хувиар, Багануур дүүрэгт 0.4 хувиар буурсан байна.

Зураг 1. Чингэлтэй дүүргийн гэмт хэрэг, улс, нийслэлийн дүнд эзлэх хувиар




Монгол Улсын нийт гэмт хэргийн дүнд Чингэлтэй дүүргийн эзлэх жин 2012 онд 8.2 хувь байсан бол 2018 онд 7.7 хувь болж 0.5 пунктээр, нийслэл хотын дүнд эзлэх хувь 13.9 хувь байсан бол 10.8 хувь болж 3.1 пунктээр

тус тус буурсан байна. Энэхүү бууралт нь гэмт хэргийн гаралтанд нөлөөлөх хүчин зүйлс буурч, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсэн Цагдаагийн бие бүрэлдэхүүний хүчин чармайлтыг илтгэж байна.

Зурагнаас харахад 2013 оноос гэмт хэргийн гаралт буурч байсан боловч 2016 оноос эргэн өссөн байна (Зураг2). Мөн дүүргийн гэмт хэргийн өсөлт улс, нийслэлийн гэмт хэргийн өсөлтөөс тогтмол доогуур явж байна.

Дүүргийн гэмт хэргийн өсөлтийн хувь 2018 онд улсын дүнгээс 10.2 пүнктээр, нийслэлийн дүнгээс 14.8 пүнктээр бага байна.

Зураг 2. Гэмт хэргийн өсөлт, оноор



Дүүргийн Цагдаагийн I хэлтэс нь 1-9 дүгээр хороог хариуцан ажилладаг, Цагдаагийн II хэлтэс нь 10-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрийг хариуцан ажилладаг болно. Хүснэгтэд гэмт хэргийн тоог Цагдаагийн I, II хэлтэст бүртгэгдсэн дүнгээр үзүүлэв.

Хүснэгт 2. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангилалаар, оноор

Гэмт хэргийн төрөл	2017			2018		
	Нийт дүн	Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс	Нийт дүн	Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс
Нийт гэмт хэрэг	2 719	1 415	1 304	2 776	1 629	1 147
Хүнийг алах	17	4	13	19	6	13
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	25	9	16	16	7	9
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	669	257	412	601	264	337
Гэр бүлийн хүчирхийлэл	-	-	-	5	-	5
Хүчиндэх	24	10	14	21	4	17
Хулгайлах	1 167	502	665	1 013	476	537
Дээрэмдэх	113	66	47	87	54	33
Залилан мэхлэх	377	321	56	616	519	97
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	-	-	-	4	3	1
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	62	42	20	51	24	27
Бусад	265	204	61	348	272	76


Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.6-д заасны дагуу гэмт хэргийг ангилалаар нь хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилдаг байсан бол 2017 оны 5 сарын 11-ний өдөр батлагдсан шинэчилсэн найруулгаар гэмт хэргийн ангилалыг ХӨНГӨН, ХҮНД гэсэн 2 ангилалтай байхаар өөрчилсөн байна. Иймд 2018 оны гэмт хэргийн ангилалд хүндэвтэр болон онц хүнд гэж бүртгэгдсэн хэрэг үүсээгүй болно.

Хүснэгт 3. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангилалаар, оноор

Гэмт хэргийн төрөл		2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт гэмт хэрэг		1 807	2 115	2 393	2 254	2 337	2 719	2 776
Гэмт хэргийн ангилалаар	Хөнгөн	798	1 018	1 168	1 050	1 103	1 503	2 043
	Хүндэвтэр	755	868	1 001	1 011	1 078	537	-
	Хүнд	204	177	172	142	107	653	733
	Онц хүнд	50	52	52	51	49	26	-

Зурагнаас харахад 2012-2016 он хүртэл онц хүнд гэмт хэрэг 1-3 хувийг, хүнд гэмт хэрэг 10 орчим хувийг эзэлдэг байсан бол хөнгөн болон хүндэвтэр гэмт хэрэг нийт хэргийн 80-90 хувийг эзэлдэг байв. Харин 2017 оноос хөнгөн болон хүнд гэмт хэргийн тоо өссөн байна (Зураг3).

Зураг 3. Бүртгэгдсэн гэмт хэргийн тархалт, ангилалаар, оноор



Дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 2018 оны нийт гэмт хэргийн 73.6 хувийг хөнгөн гэмт хэрэг, 26.4 хувийг хүнд гэмт хэрэг эзлэж байна. Энэ нь үйлдэгдэж буй 4 хэрэг тутмын 1 нь хүнд гэмт хэрэг байгааг илтгэн харуулж байна.

Хүний амь, бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 33 (5.3%)-аар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 57 (3.4%)-аар тус тус өссөн бол тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 11 (17.7%)-аар, бусад гэмт хэрэг 5 (1.7%)-аар тус тус буурсан байна.

Хүснэгт 4. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн төрлөөр, оноор

Гэмт хэргийн төрөл	2014	2015	2016	2017	2018	Өөрчлөлт	2018/2017
Нийт гэмт хэрэг	2393	2254	2337	2719	2776	57	2.1
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	697	547	563	628	660	32	5.1
<i>Хүнийг санаатай алах</i>	16	13	14	17	19	2	11.8
<i>Бусдын бие махбодид гэмтэл учруулах</i>	663	524	544	586	625	39	6.6
<i>Бусдыг амиа хорлоход хүргэх</i>	18	10	5	25	16	-9	-36.0
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1095	1068	1276	1659	1716	57	3.4
<i>Хулгай</i>	723	722	908	1167	1013	-154	-13.2
<i>Булаалт</i>	18	14	24	2	-	-2	-100.0
<i>Дээрэм</i>	66	41	54	113	87	-26	-23.0
<i>Залилан</i>	288	291	290	377	616	239	63.4
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	179	159	125	80	64	-16	-20.0
<i>Хүчиндэх</i>	18	13	17	24	21	-3	-12.5
<i>Танхайрах</i>	161	146	108	56	43	-13	-23.2
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	116	142	108	62	51	-11	-17.7
Бусад гэмт хэрэг	306	338	265	290	285	-5	-1.7

Гэмт хэргийн төрлөөр нарийвчлан авч үзвэл залилангийн гэмт хэрэг хамгийн өндөр буюу 63.4 хувиар, хүнийг санаатай алах хэрэг 11.8 хувиар, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 6.6 хувиар тус тус өссөн байна.

Булаах гэмт хэрэг 100 хувиар, бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 36.0 хувиар, танхайрах хэрэг 23.2 хувиар, дээрэмдэх хэрэг 23.0 хувиар, хулгайн хэрэг 13.2 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 12.5 хувиар тус тус буурсан байна.



Хүснэгт 5. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хороогоор, гэмт хэргийн төрлөөр

Хороо	Гэмт хэргийн төрөл											Бусад
	Бүх хэрэг	Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Гэр бүлийн хүчирхийлэл	Хүчиндэх	Хулгайлах	Дээрэмдэх	Залилан мэхлэх	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	
ДҮҮРГИЙН ДҮН	2 776	19	16	601	5	21	1 013	87	616	4	51	348
1 хороо	249	-	-	19	-	-	51	7	127	-	2	43
2 хороо	205	-	-	20	-	-	71	7	77	-	3	27
3 хороо	278	-	2	37	-	-	98	6	89	-	3	43
4 хороо	241	1	1	33	-	1	43	6	79	2	3	72
5 хороо	236	3	-	44	-	1	52	5	88	-	7	36
6 хороо	136	-	-	34	-	-	35	5	32	1	3	26
7 хороо	134	2	2	40	-	1	65	9	8	-	-	7
8 хороо	66	-	-	15	-	-	23	7	10	-	-	11
9 хороо	84	-	2	22	-	1	38	2	9	-	3	7
10 хороо	105	-	2	39	1	3	44	-	6	-	2	9
11 хороо	112	2	-	31	-	1	47	1	21	-	2	7
12 хороо	199	1	-	81	-	4	77	4	9	-	4	19
13 хороо	99	2	-	34	-	2	42	7	6	-	1	5
14 хороо	78	-	-	28	-	-	35	4	6	-	-	5
15 хороо	58	-	1	20	-	-	24	4	5	-	-	4
16 хороо	85	2	-	21	1	1	48	3	4	-	1	5
17 хороо	84	-	3	26	2	1	38	4	5	-	3	4
18 хороо	90	2	2	23	1	2	41	4	11	-	-	5
19 хороо	237	4	1	34	-	3	141	2	24	1	14	13

Гэмт хэрэг үйлдэгсэд 2018 онд 1137 болж өмнөх оноос 293 (20.5%) хүнээр өссөн байна. Гэмт хэрэг үйлдэгсэдийн 14.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба уг үзүүлэлт өмнөх оноос 5.3 пунктээр буурсан байна.

Хүснэгт 6. Гэмт хэрэг үйлдэгсэд, насны ангилалаар, оноор


Насны ангилал	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт гэмт хэрэг үйлдэгч	1 590	1 756	1 832	1 682	1 875	1 430	1 137
15 хүртэл	38	30	29	18	26	34	42
16-17 нас	87	81	79	52	74	68	48
18-24 нас	527	521	484	454	457	359	268
25-29 нас	280	359	400	394	384	310	215
30-34 нас	224	236	260	265	318	219	213
35-39 нас	161	185	209	174	212	132	123
40-44 нас	132	150	151	129	169	108	101
45-49 нас	63	97	104	76	108	83	55
50-54 нас	48	67	69	66	84	57	32
55-59 нас	20	21	27	33	29	40	26
60-64 нас	7	7	9	14	4	14	7
65-69 нас	3	-	7	5	7	2	2
70, түүнээс дээш	-	2	4	2	3	4	5

Дүүргийн нийт хүн амын 0.7 хувь, эмэгтэйчүүдийн 0.2 хувь нь гэмт хэрэг үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн иргэдийн ихэнх буюу 42 хувь нь 18-29 насны залуус байгаа бол 46 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байна.

Улсын хэмжээнд 2018 онд нийт 516 сурагч гэмт хэрэг үйлджээ. 15 хүртэлх насны хүүхдийн гэмт хэрэг үйлдэлт жил ирэх бүр нэмэгдэж байгаа нь өсвөр насны хүүхдүүдэд тавих хараа хяналтыг сайжруулах, мөн гэмт хэрэгт холбогдохгүй байх, болзошгүй эрсдэлээс сэргийлсэн сургалт, мэдээллийг түгээхэд түлхүү анхаарах шаардлагатай байна.

Зураг 4. Гэмт хэрэг үйлдэгсэд насны бүлгээр, хувиар, 2018 он



Зураг 5. Гэмт хэрэг үйлдэгсэд боловсролын түвшинээр, хувиар, 2018 он



Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо 2018 онд 2633 болж өмнөх оноос 59

(2.3%) хүнээр өссөн байна. Хохирсон иргэдийн 47.6 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 0.5 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.


Хүснэгт 7. Гэмт хэргийн улмаар хохирсон иргэдийн тоо, насны бүлгээр, оноор

Насны ангилал	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт	1 760	2 101	2 241	1 966	2 363	2 574	2633
7 хүртэл	-	-	-	-	-	11	6
8-13 нас	37	58	32	41	43	49	38
14-17 нас	78	68	87	52	57	92	80
18-24 нас	364	430	405	301	339	349	336
25-29 нас	330	383	452	374	444	471	465
30-34 нас	269	303	363	309	340	424	438
35-39 нас	230	270	270	237	328	310	347
40-44 нас	155	179	216	195	276	266	283
45-49 нас	116	166	156	164	195	213	225
50-54 нас	92	121	109	148	170	166	181
55-59 нас	47	61	88	77	92	110	117
60-64 нас	17	30	32	27	34	60	60
65-69 нас	13	10	18	21	24	28	35
70, түүнээс дээш	12	22	13	20	21	25	22


Дүүргийн нийт хүн амын 1.7 хувь, эмэгтэйчүүдийн 1.5 хувь нь гэмт хэргийн хохирогч болсон байна.

Нийт хохирогчдын 41.7 хувийг тухайн үед нь хамгаалалтанд авч ажилласан байна. Мөн 24 иргэн өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж хохирогч болсон бол 91 хүн архидан согтуурч байх үедээ хохирсон байна. Энэ нь өмнөх оноос 27 (42.2%)-оор өссөн байна.

Зураг 6. Гэмт хэргийн хохирогч хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, хувиар, 2018 он




Зураг 7. Гэмт хэргийн хохирогч насны бүлгээр, хувиар, 2018 он




Зураг 8. Гэмт хэргийн хохирогчийн тоо, оноор

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэд 47 болж өмнөх оноос 6 (11.3%)-аар буурсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн гол хохирогч эхнэр байх тохиолдол 2018 онд 16 бүртгэгдэж өмнөх оноос 8 (33.3%)-р буурсан байна. Харин гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамтран амьдрагч байх тохиолдол 22 бүртгэгдэж өмнөх оноос 9 (69.2%) хүнээр өссөн байна.



Зураг 9. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар, хувиар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг төрлөөр авч үзвэл 10 хэрэг тутмын 3 нь гэр, орон сууцанд, 2 нь гудамж талбайд, 1 нь олон нийтийн газар, 1 нь аж ахуй нэгж байгууллагад, 3 нь нийтийн тээвэр, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, авто зам гэх мэт бусад газар үйлдэгдэж байна.



Зам тээврийн осол, зөрчил: Дүүргийн Замын цагдаагийн тасгийн бүрэлдэхүүний гудамж, замд хийсэн хяналт шалгалтаар 2018 онд 123655 зөрчил илрүүлснээс нийт 108296 жолоочийг 2.9 тэрбум төгрөгөөр торгож ажилласан байна.

Өмнөх оноос илрүүлсэн зөрчил 16548 (14.4%), торгуулсан жолооч 9055 (9.1%), торгуулсан мөнгөний хэмжээ 187.7 (6.5%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 8. Зам тээврийн зөрчлийн тоо, зөрчлийн хэлбэрээр, оноор

Зөрчлийн хэлбэр	2017	2018	Өөрчлөлт	2018/ 2017
НИЙТ ЗӨРЧИЛ	107 107	123 655	16 548	15.4
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон	2 473	2 570	97	3.9
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эрх нь дуусан боловч тээврийн хэрэгсэл жолоодсон	318	329	11	3.5
Улсын дугаарын хязгаарлалттай өдөр хориглосон бүсээр зорчсон	5 473	-	-5 473	-100.0
Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	7 158	8 570	1 412	19.7
Хамгаалах бүс хэрэглээгүй	10 904	9 393	-1 511	-13.9
Хориглосон нөхцөлөөр зогссон	29 117	32 247	3 130	10.7
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	3 020	4 349	1 329	44.0
Эгнээ байраа буруу эзэлсэн	10 021	10 112	91	0.9
Бусад зөрчил	38 623	56 085	17 462	45.2

Онцгой байдал: Дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь 2018 онд Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дээр гарсан 863 гал түймрийн дуудлага хүлээн авсан нь өмнөх оноос 193 (28.8%)-аар өссөн байна. Мөн зарцуулсан хөрөнгө өмнөх оноос 50.6 хувиар өссөн бол хамгаалсан хөрөнгө 87.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 9. Гал түймрийн дуудлага, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, оноор

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016	2017	2018	2018/ 2017
Дуудлагын тоо	Тоо	796	670	863	28.8%
Гал түймэр	Тоо	486	471	651	38.2%
Иргэд унтраасан гал түймэр	Тоо	246	169	175	3.6%
Өөрөө унтарсан гал түймэр	Тоо	36	20	25	25.0%
Худал дуудлага	Тоо	28	10	12	20.0%
Ашиглагдсан үс	Тонн	550	743.8	879.5	18.2%
Ашиглагдсан шатахуун	Литр	23800	26531.1	26751.1	0.8%
Зарцуулсан, мөнгө	Сая.төг	41.2	43.9	66.1	50.6%
Аварсан хүний тоо	Тоо	523	567	288	-49.2%
Унтраасан барилга байшингийн тоо	Тоо	250	208	225	8.2%
Нийт өмч хөрөнгө	Сая.төг	10300	3800	7130	87.6%



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ 2018

Бүртгэгдсэн гэмт хэрэг

2018 - 2667
2017 - 2719

ГЭМТ ХЭРЭГ

УЛС
36220

НИЙСЛЭЛ
25652

Гэмт хэргийн төрөл

ХӨНГӨН - 2043
ХҮНД - 733



Хэрэг илрүүлэлт

2018 - 34.1%
2017 - 35.1%



Гэмт хэргийн ихэнх буюу 34.4 хувь нь 06-14.00 цагийн хооронд гэр, орон сууцанд үйлдэгдсэн байна.

Ял шийтгэгдсэн хүн

2018 - 96
2017 - 42

ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧ ХЭРЭГТЭН | ХОХИРОГЧ

НИЙТ:

2018 - 1137 | **2018 - 2633**
2017 - 1430 | **2017 - 2574**



ЭМЭГТЭЙ:

2018 - 166 | **2018 - 1253**
2017 - 284 | **2017 - 1238**



ХҮҮХЭД:

2018 - 90 | **2018 - 124**
2017 - 102 | **2017 - 152**

